

**АЛТАЙ ЗАМ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо:	2018.04.04	
Эхэлсэн цаг:	16:00	
Дууссан цаг	17:45	
Хаана:	Улаанбаатар хот, СХД 4-р хороо, "Алтайн Зам" ХК – ийн хурлын танхим	
Хурлын төрөл:	☒ Ээлжит хурал	☐ Ээлжит бус хурал
Дугаар:		

Хурлын ирц

1	М.Нямдаваа	ТУЗ-ийн дарга	☒ ирсэн	☐ ирээгүй
2	С.Балжинням	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
3	Ц.Ганцэцэг	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
4	Г.Сономжамц	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
5	Б.Бат-Ирээдүй	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
6	С.Баянчулуун	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
7	С.Баянмөнх	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
8	Т.Мөнгөнцацрал	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
9	Н.Энхцэцэг	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй

ТУЗНБД Т.Мөнгөнцацрал: Алтайн Зам ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хуралдаанд 50056 ширхэг хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийг итгэмжлэлээр төлөөлөн С.Балжинням оролцохоор бүртгүүлсэн байна. Оөр хувьцаа эзэмшигч хуралдаанд оролцохоор бүртгүүлээгүй бөгөөд урьдчилан санал ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй болно. Ингээд Компанийн тухай хуульд заасан 92 хувийн хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөрт тооцон тогтоол гарч байна.

	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Ньюпрогресс Групп ХХК-ийг төлөөлөн С.Баянчулуун	50056 ширхэг	92%
	Нийт	50056 ширхэг	92%

Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны ирц нь Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйл 69.1-д заасан нөхцлийг хангасан байх тул хуралдааныг нээж байна.

Хурлын дарга М.Нямдаваа:

Хуралд хүрэлцэн ирсэн эрхэм ТУЗ-ийн гишүүддээ баярлалаа. Энэ удаагийн ээлжит хуралд С.Балжинням Хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийн итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцож байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа шууд орьё.

Хурлын дарга М.Нямдаваа: ТУЗ-ийн ТУЗ2018001 тоот Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг дүгнэх тухай, ТУЗ2015002 тоот Ногдол ашгийн тухай, ТУЗ2015007 тоот санхүүгийн аудит хийх байгууллагыг сонгон гэрээ байгуулах эрх олгох тухай тогтоолуудыг тус тус уншин танилцуулав.

...Хурлын даргын хувиар оролцож байгаа миний хувьд хэлэлцэх асуудалтайгаа бүрэн танилцсан байгаа. Тэгэхээр шууд санал хураалтаа эхлүүлээд явах нь зүйтэй байна.

С.Балжинням: Асууж тодруулах зүйлгүй гэснээр санал хураалтыг эхлүүлэв

Хурал зохион байгуулах болон тооллогын комиссын дарга санал хураалтыг эхлүүлж, 13:45 цагт тооллын комиссын дүнг танилцуулав.

Т.Мөнгөнцацрал өнөөдрийн хуралдаанд эцнээ байдлаар санал өгсөн хувьцаа эзэмшигч байхгүй нийт 50056 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцлоо. Тооллогын комиссоос дараахи тогтоолыг гаргаж байгаа бөгөөд тогтоолд саналын хуудсыг хавсаргасан болно.

Дараахи тогтоолын төсөлд санал хураалт явууллаа.

Нийт 50056 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцон 1 ширхэг хүчинтэй саналын хуудас тоолоо. Хүчингүй болсон саналын хуудас байхгүй

	Хэлэлцсэн асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	ХЭ2018001	50056	0	0
2	ТУЗ-ийн 2017 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	ХЭ2018002	50056	0	0
3	ТУЗ-ийн гишүүдийн эрхийг сунгах	ХЭ2018003	50056	0	0

Шийдвэрлсэн нь .

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар

ХЭ2018001, ХЭ2018002, ХЭ2018003, тоот тогтоолын төслийг 100 хувь дэмжин тогтоол гаргаж, энэ тухай холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг ТУЗНБД-д үүрэг болгов.

Хурлын дарга М.Нямдаваа: Энэ удаагийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал хурааж дууссан тул хуралдааныг хааж байна.

Хуралдаан 2018 оны 04 сарын 04-ны 17:46 цагт өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ТУЗНБД

Т.МӨНГӨНЦАЦРАЛ

ХЯНАСАН

ХУРЛЫН ДАРГА

М.НЯМДАВАА